

# ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр

**Тендер шалгаруулалтын нэр:** Халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаан хангамжид холбох /багц-2/ “ДЦС-4” ТӨХК-иас Яармаг хүртэлх дулааны 2ф600мм голчтой дулааны шугамын барилга угсралтын ажил.

**Тендер шалгаруулалтын дугаар:** ЭХЯ/201812005

Эрчим хүчний яам нь эрх бүхий тендерт оролцогчдоос Халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаан хангамжид холбох /багц-2/ “ДЦС-4” ТӨХК-иас Яармаг хүртэлх дулааны 2ф600мм голчтой шугамын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) –хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендерт оролцохын тулд эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар цахим тендерийн хураамж төлнө. Тендерийн хүчинтэй хугацаа нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоног байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 3 жил /2015, 2016, 2017/ аль нэгэн жилийн борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн **70%**.

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Санал болгож буй үнийн дүнгийн **70%** буюу түүнээс дээш хувь

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 3 жил: 2015, 2016, 2017 он.

**Сүүлийн гурван жилийн аль нэг жилд нь хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Санал болгож буй үнийн дүнгийн **70%**-иас багагүй байна.

**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:**

*Зураг төсөл боловсруулах байгууллага нь Эрчим хүчний яамнаас олгогдож буй:*

*-03.9.9. 0-40.0-өөс доош кгх/см<sup>2</sup> даралттай шугам хоолой, ЦТП-ны ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах*

*Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь Эрчим хүчний яамнаас олгогдож буй:*

*-03.5.2. 0-40кгх/см<sup>2</sup> даралттай дулааны шугам хоолой, ЦТП-ны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ*

*-03.2.1 0.4-10кВ Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар*

Тендерийн хамт: **38 000 000 /Гучин найман сая/** төгрөгийн дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 15:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 15:30 цагт Эрчим хүчний яамны хурлын зааланд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх “эрхгүй”  
Дотоодын давуу эрх **тооцно:**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Эрчим хүчний яам, 17060 Хан-Уул дүүрэг 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр, 300-а тоот Утас: 62263061 [www.energy.gov.mn](http://www.energy.gov.mn)